

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх
ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний
зөвлөлийн хуралдааны тэмдэглэл**

Хуралдаан 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 17 цагт эхлэх байсан боловч Ерөнхий сайд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны хурал болон Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд асуудал оруулж хэлэлцүүлсэн тул гишүүд түр хүлээв.

Хуралдаан 17 цаг 55 минутад эхлэв. Хуралдаанд М.Энхболд, Л.Жавзмаа, П.Очирбат, Д.Батбаатар, Н.Алгаа, Д.Батбаяр нар оролцов. Гишүүн Ч.Улаан, Л.Гантөмөр, Н.Баяртсайхан нар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаантай, Б.Жаргалсайхан, Цэвээнжав, П.Бямбацэрэн нар хөдөө ажлаар явсан тул оролцоогүй. И.Эрдэнбаатар ирээгүй болно. Хуралд зөвлөх Г.Цогтсайхан, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нар урилгаар оролцов. Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанаас ажилтан байв.

М.Энхболд-Улсын Их хурлын чуулган хуралдаж байгаа тул хуралдаанаа эхлэв. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөл оны эхэнд байгуулагдсан. Анхны хуралдаанаа хийж байна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох материалыг гишүүдэд хүргүүлсэн. 4 асуудал хэлэлцэнэ. Хуралдааныг нээж байна.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу нарийн бичгийн дарга Д.Батбаяр товч танилцуулга хийнэ.

Д.Батбаяр-Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын талаар үг хэлж танилцуулга хийв. Хэлсэн үгийг хавсаргав.

М.Энхболд-Зохиож байгаа ажлын талаар танилцууллаа. Асуулт байна уу?

П.Очирбат-Чухал санаачлага, манайх заавал орох ёстой. Санаачлагад орох орон улсын төсвийн орлогын 25 хувь гэж шалгуур байгаа, энэ шалгуурыг Засгийн газраас оруулж байгаа хуулийн төслөөр бол хангана, Өөр хуулийн төслүүд батлагдвал Оюутолгой, Тавантолгой гээд том уурхайнууд ашиглагдахгүй. Экспортын татвар нэмэх, гэнэтийн өсөлтийн татвар батлагдвал одоогийн 17 хувь ч өнгөрнө. Бид энэ санаачлагад орохгүйгээр явахгүй. Нөөц, баялаг гэдэг 2 өөр ойлголт. Алтны нөөц гэхэд 200 тн орчим бол, баялаг 3000 тн байна. Зэсийн хувьд нөөц бол Эрдэнэтийн 4 сая тн бөгөөд, бусад нь баялаг юм. Баялаг гэдэг бол "яндаж болдоггүй далай шиг, яасан баян орон бэ" гэж дууны үгэнд гардаг шиг мөрөөдөл юм. Манайд 800 орд бий гэж геологиуд ярьдаг. Орд гэдгийг илрэл гэдэг утгаар ойлгох ёстой. Дэлхийн хэлээр бид ярьж сурах хэрэгтэй байна. Энэ шалгуур, гарах, гарахгүй хууль 2-ыг сайн ярих хэрэгтэй байна. Бид энд орно. Шалгуурыг хангахгүй. 3 хууль батлагдвал шалгуурын 60 хувьд ч хүрэхгүй. Яах вэ.

Д.Батбаяр-Түрүүчийн Засгийн газар санаачлагад орох асуудлыг дэмжсэн. Дэлхийн банк дэмжиж байгаа. Дэлхийн банк зөвлөх тавьж ажиллуулж байгаа. Ажлын хэсгийн хуралдааныг 2006 оны 4 дүгээр сарын 14-нд хийсэн. Төлөвлөгөө гаргасан, 3 талын тэгш харилцааг бий болгох хэрэгтэй байна. 4000 төрийн бус байгууллагаас сонгож төлөөллөө сонгоно, хуулиудад өөрчлөлт орно.

П.Эрдэнэжаргал-П.Очирбат гуайн хэлсэн нь жинхэнэ шалгуур биш ээ. Номын 7 дугаар хуудсанд шалгуур байгаа. Санаачлага нь уул уурхайн салбарын

цаашдын хөгжилд хувь нэмэр оруулна. Таны яриад байгаа зүйл гол шалгуур биш ээ.

М.Энхболд-Зөвлөлийн гишүүд мэдээлэл авлаа. Дараагийн асуудалд ороё.

Г.Цогтсайхан-Эхлээд П.Очирбат гуайн асуултанд хариулая. Санаачлагад Монгол Улс элссэн. Элсэж байгаа улсын жагсаалтад Монгол Улс бүртгэгдсэн байгаа.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхэд Дэлхийн банк, Английн олон улсын хөгжлийн агентлаг 2 туслана. Үндэсний зөвлөлд оруулж байгаа ажлын төлөвлөгөөнд туссан байгаа. Дэлхийн банк дэргэдээ энэ зорилгоор сан байгуулсан байгаа. Тэрнээс нь хэд хэдэн чиглэлд туслана. 1/чадавхийг бэхжүүлэх /төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэний нийгэм/, 2/санаачлагыг хэрэгжүүлэхэд зориулж зарим техникийн туслалцаа үзүүлэх, 3/уул уурхайн компаниуд улсад татвар, төлбөрөө зөв төлж үү, зөв мэдээлж байна уу, улс авснаа зөв мэдээлж байна уу гэдэгт аудит хийхэд туслах, 4/ажлын хэсэгт орон тооны ажилтан ажиллуулах /Нигер Улс Төрийн хороо байгууллагад Нарийн бичгийн дарга нарын газар байгуулсан, түүний зардлыг гаргасан байсан/, техник туслалцаа үзүүлнэ.

Английн Олон улсын хөгжлийн яам /Элчин сайдын яам/-тай яривал тусламж үзүүлэх боломжтой. Аудитын чиглэлээр туслалцаа үзүүлдэг. Улсад төлсөн татвар, түүнээ бүрэн мэдээлж байна уу, суманд машин авч өгсөн зэргээ ч мэдээлэх ёстой. Далдуур өгснөө мэдээл гэж шахаж байгаа. Улс компаниас авсан бүх орлогоо иргэдэд мэдээлэх. 24 сарын хугацаатай хагас сая.ам долларын хүсэлт тавиад байгаа.

П.Эрдэнэжаргал-Европын сэргээн босголт, хөгжлийн банк тусламж үзүүлэх сонирхолтой юм билээ.

Г.Цогтсайхан-Санаачлагыг Дэлхийн банк, их наймын Сангийн сайд нар хэлэлцсэн цаашид дэмжлэг үзүүлэх сонирхолтой байгууллагууд олон бий. Азийн хөгжлийн банк, олон улсын санхүүгийн байгууллагын сонирхож байгаа. Хэрвээ манай улс анхны тайлангаа гаргавал үргэлжүүлж мөнгө авах боломжтой.

М.Энхболд-Тодруулах зүйл юу байна. Яам, Засгийн газар ажлаа хийгээд явна. Ямар түвшинд байх вэ? Хүсэлт тавих ажлаа зохион байгуулая. Ашигт малтмалын тухай хууль батлагдахаар асуудал өөр болно. Засгийн газрын төслийг ярьж байна. Зэсийн зах зээлийн үнэ өнөөдөр 8148 болсон байна. Улсууд энэ орлогоос татвар авмаар санагдаад байх шиг байна. Гэхдээ одоогийн төсөл нь зөвхөн зэс букуу 1 үйлдвэрт хандаад байгаа. Оюутолгой, Тавантолгой загвар гарна. Тал талаас нь ярилцах зүйл гарна. Д.Батбаяр материал бэлд.

П.Очирбат-Дэлхийн банкнаас тусламж авах хэрэгтэй. Дотроо нөөцөө мэдэх хэрэгтэй. Дотоод боломжоо бүү хаа. Жаахан ч гэсэн боломж бий болгох хэрэгтэй. Охин компаниар дамжуулж тунгалаг болгоход чухал юм. Манайх нөөц баялгаа мэдэж, Улсын Их Хурал төрийн бодлого болгох нь чухал.

М.Энхболд-Зөвлөлийн ажиллах журмын төслөө хэлэлцэе. Та бүхэн тараасан тул танилцуулах хэрэггүй. Шууд саналаа хэлэе.

П.Очирбат-төслийн 9-ийн "хэлэлцэх асуудлын жагсаалт" гэснийг хасах, "бичгээр" хүргүүлнэ гэх, 12-ын үндэсний зөвлөл нь ажлын хэсэгтэй байна

гэснийг анхаарах, 16-г хасах, 22-т шийдвэр чухал, шийдвэрийг зааж өгөх, ажлын алба гэснийг ойлгосонгүй.

М.Энхболд-Өөр санал байна уу. Алга. Очирбат гуайн саналыг тусгаад батлая. Ажлын төлөвлөгөөний төслөө хэлэлцэе.

Л.Жавзмаа-1 дэх хэсгийг Байнгын хороо, Засгийн газрын гишүүд гэх, 14-т байгаа "яаралтай" гэдгийг анхаарах.

П.Очирбат-"туслан дэмжүүлэх гэдгийг "хамтарч ажиллах" гэх

Д.Батбаатар-18-ыг ойлгомжтой болгох

Д.Батбаяр-18-ыг өөрчлөн найруулснаа уншиж танилцуулав.

Н.Алгаа-жижиг, дунд олборлох үйлдвэрлэлийг яах вэ?

Г.Цогтсайхан-Дэлхийн банк нефть, хийг бүгдийг оруулах зөвлөлгөө өгдөг, мөн хэтэрхий жижиг аж ахуйн нэгж оруулбал ашиг олж чаддагүй, харин ч зардал л нэмэгддэг гэдэг юм билээ. Татварын байгууллагын судалгаагаар 214 компани татвар төлсөн. Зарим аж ахуйн нэгж 5000 \$ татварт төлсөн байдаг. Дэлхийн банк жижиг аж ахуйн нэгж хэрэггүй гэдэг.

П.Очирбат-Бэлтгэл ажлын төлөвлөгөө юу. Хэд хэдэн үе шаттай юм байна.

Д.Батбаяр-Бид бэлтгэл ажлын төлөвлөгөө гээд бэлтгэл хангах хүрээнд ажлаа төлөвлөсөн.

Л.Жавзмаа-Зөвхөн энэ онд хийх ажил байна.

Г.Цогтсайхан-Мөнгө гаргах ажлын малгай, хугацаа 2-ыг оруулсан.

П.Эрдэнэжаргал-Тайлан гаргах асуудлыг оруулах. 9 дүгээр сард Норвегид олон улсын хурал нь болно. 2007 оны 7 дугаар сард тайлан гаргах.

Н.Алгаа-Бэлтгэл ажлаа төлөвлөсөн байна.

П.Очирбат-Танай тайланг тунгалаг болгоно гээд байдаг. Болор 2 өнгөтэй, Усан болор, утаат болор. Бид усан болор болгох гэж байгаа. Казакстанд төрийн аудит байхгүй тул гадныхан аудитыг хийж байгаа.

М.Энхболд-Гишүүдийн саналыг тусган төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлж эхэлье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Хүрэлцэн ирсэн гишүүдэд баярлалаа.


Хуралдаан 17 цаг 30 минут хүртэл үргэлжлэв.

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн:
Засгийн газрын ахлах референт



Э.СУМЪЯА

Танилцсан:
Зөвлөлийн нарийн бичгийн дарга



Д.БАТБАЯР